



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 1/318

Ховд

Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолын 3.1.2, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны

дарга: Г.Гончигсүрэн - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Б.Гантулга - Аймгийн Засаг Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэр, худалдаа хариуцсан мэргэжилтэн

Т.Сайнбаяр- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орлогч дарга

Ж.Өлзийбаяр – Үйлдвэрлэл, хоршоолол, ахуйн үйлчилгээний нэгдсэн холбооны тэргүүлэгч

Э.Энхсайхан – Аймгийн баялаг бүтээгчдийн холбооны дарга

Н.Гомбодорж – Аймгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэвшил холбооны тэргүүн

Б.Ганзориг – Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Зах А/818 Чх  
02 01332

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэдорж – Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөнгөн,  
жижиг, дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэн

2.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмын дагуу санхүүжилтийн эх үүсвэрт багтаан шаардлага хангасан төслүүдийг дэд хороогоор хэлэлцүүлж, аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулж, төсөл сонгон шалгаруулалт явуулахыг дэд хорооны дарга /Г.Гончигсүрэн/, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ